



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/389

Мандалговь

2021-2022 оны төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажил, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухайн хуулийн хэрэгжилтийн үзлэгийг эрчим хүчний салбарт зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2, Эрчим хүчний тухай хуулийн 11.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэлд хяналт шалгалт хийх, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үзлэгийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: М.Анхбаяр (Аймгийн Засаг даргын орлогч дарга)

Гишүүд:

Л.Доржбат (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга,

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн дарга)

Н.Дэлгэрмаа (Нийгмийн бодлогын хэлтсийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого хариуцсан мэргэжилтэн)

О.Мөнхзул (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Барилга, хот байгуулалт, дэд бүтцийн бодлого хариуцсан мэргэжилтэн)

Б.Золжаргал (Мэргэжлийн хяналтын газрын Эрчим хүч, харилцаа холбооны улсын байцаагч)

П.Нямсүрэн (Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн улсын байцаагч)

И.Тогооч (Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн эрүүл ахуйн улсын байцаагч)

Б.Бямбасүрэн (Орон нутгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн орон тооны гишүүн)

Б.Мөнхчулуун (Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга, Позитивийн сургагч багш)

О.Цэнгэлмаа (Аймгийн Үйлдвэрчний Эвлэлийн холбооны сургагч багш, арга зүйч)

Нарийн бичгийн дарга: Э.Цэвэлмаа (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2. Эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн үзлэгийг 2021 оны 10 сарын 19-ний өдрөөс 10 сарын 30-ныг хүртэлх хугацаанд зохион байгуулсан ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, үр дүнг тайлагнахыг ажлын хэсгийн дарга болон гишүүдэд үүрэг болгосугай.

3. Өвөлжилтийн бэлтгэл болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзлэгийн хуваарийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

481210524

4. Зардалд шаардагдах хөрөнгийг судалж, шийдвэрлэхийг Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга (М.Анхбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ



Аймгийн Засаг даргын 2021 оны
дугаар сарын 10-ны өдрийн 19
дугаар захирамжийн хавсралт

2021-2022 ОНЫ ТӨВ СУУРИН ГАЗРЫН ӨВӨЛЖИЛТИЙН БЭЛТГЭЛ АЖИЛ,
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН УЛСЫН ҮЗЛЭГИЙГ ЭРЧИМ ХҮЧНИЙ
САЛБАРТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ

№	Байршил	Үзлэгийн үйл ажиллагааны чиглэл		Хамрагдах байгууллагын нэр	Хугацаа
		Цахилгаан эрчим хүч түгээх, дамжуулах	Дулаан үйлдвэрлэх болон түгээх		
1	Сайнцагаан	Түгээх		Багануур зүүн өмнөд бүсийн Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Дундговь Цахилгаан түгээх сүлжээний салбар (Г.Мягмарсүрэн)	2021.10.19
2	Сайнцагаан	Дамжуулах		Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК Говийн бүсийн салбар (С.Намжилцэрэн),	2021.10.19
3	Сайнцагаан		+	"Дундговь Ус" ОНӨҮГазар (О.Бархүү)	2021.10.19
4	Сайнцагаан		+	"Тэвшийнговь" ХХК	2021.10.19
5	Сайнцагаан		+	"Ариунболор" ХХК	2021.10.20
6	Сайнцагаан		+	"Их говийн түлш" ХХК	2021.10.20
7	Сайнцагаан		+	"Ган-Илч" ХХК	2021.10.20
8	Луус	Түгээх	+	"Тадайма" ХХК	2021.10.25
9	Хулд	Түгээх	+	"Говь энерги илч" ХХК	2021.10.25
10	Дэлгэрхангай	Түгээх	+	"Хангай илч дулаан" ХХК	2021.10.26
11	Сайхан-Овоо	Түгээх	+	ЭБЦТС ТӨК салбар, "Ган-илч" ХХК	2021.10.27
12	Эрдэнэдалай	Түгээх	+	"Үлэмж хурд" ХХК	2021.10.28
13	Адаацаг	Түгээх	+	"Ирмүүн түшиг" ХХК	2021.10.29
14	Дэлгэрцогт	Түгээх	+	"Ган-илч" ХХК	2021.10.30
15	Дэрэн	Түгээх	+	"ОВЛ СКАЙ" ХХК	2021.10.30
16	Цагаандэлгэр	Түгээх	+	"Ган-илч" ХХК	2021.10.25
17	Говь-Угтаал	Түгээх	+	Багануур зүүн өмнөд бүсийн Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Говьсүмбэр Цахилгаан түгээх сүлжээний салбар, "Ган-илч" ХХК	2021.10.26
18	Баянжаргалан	Түгээх	-		2021.10.27
19	Өндөршил	Түгээх	+	Багануур зүүн өмнөд бүсийн Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Говьсүмбэр Цахилгаан түгээх сүлжээний салбар, "Ирмүүн түшиг" ХХК	2021.10.28
20	Гурвансайхан	Түгээх	+	"Ган-илч" ХХК	2021.10.29
21	Өлзийт	Түгээх	+	"Ган-илч" ХХК	2021.10.30